



**БҮХ ШАТНЫ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ
ШҮҮГЧДЭЭС АВСАН САНАЛ
АСУУЛГЫН ҮНЭЛГЭЭ**

Улаанбаатар хот

2015 он

Агуулга

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Монгол Улсын бүх шатны шүүхийн ерөнхий шүүгчдийн хүрээнд “Шүүхийн шинэтгэл – 2014” хэлэлцүүлэгийг 2015 оны 2 дугаар сарын 13 өдөр зохион байгуулсан.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014 оны үйл ажиллагааны үр дүн, цаашдын зорилтын талаар шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндорж үг хэлж, шүүх байгуулах тухай хуулийн төслийн танилцуулгын талаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.Мэндсайхан хэлэлцүүлсэн. Энд хүрэлцэн ирсэн ерөнхий шүүгч нараас:

- Шүүн таслах ажиллагааны чанар, үр өгөөж
- Шүүхийн тамгын газрын үйл ажиллагаа
- Дагнасан шүүхийн тогтолцоо
- Шүүхийг цаашид ямар хэлбэрээр зохион байгуулах
- Шүүхийн захиргааны үйл ажиллагааны үнэлгээ
- Тамгын газрын үйл ажиллагааны үнэлгээ... зэрэг агуулгын хүрээнд богино хэмжээний санал асуулга авч, доорх үр дүнг үүгээр танилцуулж байна.


Асуулгын үр дүн

Хүснэгт №1		Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	
№	Утга	Тоололт	Хувь
Аль шатны шүүхийн шүүгч			
1	Давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч	12	18.5
2	Анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч	53	81.5
3	Бүгд	65	100
Шүүгчээр ажилласан жил			
1	1-5 жил	3	4.6
2	6-10 жил	17	26.2
3	11-15 жил	21	32.3
4	16-аас дээш жил	24	36.9
5	Бүгд	65	100

Судалгаанд оролцогчдын 81.5 хувь нь буюу 53 нь анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч, 18.5 хувь нь буюу 12 нь давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч хамрагдсан байна. Шүүгчдийн 4.6 хувь нь 5 хүртэл жил, 26.2 хувь нь 6-10 жил, 32.3 хувь нь 11-15 жил, 36.9 хувь нь 16-аас дээш жил шүүгчээр тус тус ажилласан байна.

График №1


Шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөө



Шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөөний өнөөгийн байдлыг судалгаанд оролцсон шүүгчдийн 35 хувь нь сайн, 60 хувь нь дунд, 3 хувь нь муу гэж үнэлсэн бол 2 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

График №2


Шүүхийн тамгын газрын үйл ажиллагаа



Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны өнөөгийн байдалд шүүгчдийн 3 хувь нь хангалттай сайн, 58 хувь нь хэвийн, 28 хувь нь доголдож байна, 11 хувь нь хангалтгүй байна гэж үзсэн байна. Үүнийг давж заалдах болон анхан шатны шүүхээр харьцуулж харвал:

График №3


Шүүхийн тамгын газрын үйл ажиллагаа (шүүхээр, хувиар)



Анхан шатны шүүхийн тамгын газрын үйл ажиллагааг хангалттай сайн (3.7%) гэж үзэх шүүгч байгаа ч давж заалдах шүүхийн тамгын газраас илүүтэйгээр доголдож байна (30.2%) гэж үзэх хувь өндөр байна.

График №4


Шүүхийн захиргаа, шүүн таслах ажиллагаа хоёрыг салгасан явдал нь



Шүүгчид шүүхийн захиргаа, шүүн таслах ажиллагаа хоёрыг тусад нь салгасан явдал нь өмнөхөөсөө сайжирсан гэж 57 хувь нь, хэвийн гэж 36 хувь нь, өмнөхөөсөө дордсон гэж 5 хувь нь тус тус үзсэн бол 2 хувь нь хараахан ялгаж мэдэхгүй байна гэж хариулжээ.


График №5

Дагнасан шүүхийн тогтолцоог хадгалах нь



Судалгаанд оролцсон ерөнхий шүүгчид дагнасан шүүхийн тогтолцоо нь зөв, цаашид хадгалах нь зөв гэж 98 хувиар буюу бүрэн бүрэлдэхүүнээрээ үзсэн байна.

График №6 Шүүхийг цаашид ямар хэлбэрээр зохион байгуулах талаар (хувиар, давхардсан тоогоор)



Судалгаанд оролцсон шүүгчид дараах саналыг бичгээр гарсаныг багцлан хүргэвэл:

- Тамгын дарга, шүүхийн захиргааны ажилтнуудыг мэргэшүүлэх, сургах (дийлэнх)
- УДШ-тэй бүх талаар хамтарч ажиллах
- Шүүгчдийн ажиллаж байгаа орчин нөхцлийг сайжруулах

Боловсруулсан:

Д.Аюуш /Социологич судлаач/

Хянасан:

С.Энхбаяр /Шүүхийн захиргааны удирдлагын газрын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч/

